



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 18

Мандалговь

Хамтарсан баг байгуулан
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэхь хэсгийн 20.1.7, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг цогцоор нь авч хэрэгжүүлэх, сар бүр тогтсон цагт хуралдуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч : Сумын Засаг дарга

Нарийн бичиг : Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд : Халамжийн мэргэжилтэн

Хэсгийн байцаагчид

Сумын Эрүүл мэндийн төвийн дарга

Багийн Засаг дарга нар

Багийн нийгмийн ажилтнууд


Сургуулийн нийгмийн ажилтнууд

Цэцэрлэгийн арга зүйчид

2.Хамтарсан багийн ажлын төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сард багтаан баталж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг Хамтарсан багийн ахлагч (С.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 49 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ